



МОНГОЛБАНК  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



# ӨРХИЙН ТӨСӨВ





Энэхүү гарын авлагыг “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд боловсруулав.

Монголбанкны зөвшөөрөлгүйгээр товхимолыг цахим болон хэвлэмэл байдлаар, бүтнээр, эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх бусад хэлбэрээр түгээхийг хориглоно.

© Монголбанк

Үнэгүй тараагдана.



## ӨМНӨХ ҮГ

---

“Иргэн баян бол улс баян” гэдэг. Энэ нь иргэн бүр эрх, үүргээ ухамсарлан, өөрийн амьдрал ахуйд эзэн болж чадвал улс орны хөгжил өөдрөг сайн байхыг өгүүлж буй хэрэг билээ. Нөгөө талаас, аливаа улсын хөгжлийн эрхэм зорилго бол ард иргэдийнхээ сайн сайхан аж байдлыг дээшлүүлэх явдал байдаг. Энэ зорилгод хүрэхэд улс орон эдийн засгийн хувьд чадамжтай, хувь хүмүүс ашиг орлого, хөрөнгө мөнгө сайтай байх нь их чухал. Төр засаг дангаараа энэ зорилгыг биелүүлэхэд хүч хөрөнгө дутах тул ард иргэдийн үүрэг, хувь нэмэр, идэвх санаачилга, оролцоо хэрэгтэй юм.

Хүний хязгааргүй хэрэгцээг хангах нөөц хүрэлцдэггүй нь хүн төрөлхтний бүх түүхэн дэх гачлан байлаа. Гэхдээ бид хязгаарлагдмал нөөцөөр хязгааргүй хэрэгцээгээ хангахын төлөө тэмүүлдэг. Тэгвэл хэрэгцээгээ сайтар хангахын тулд хязгаарлагдмал нөөц, хөрөнгө мөнгийг зөв зарцуулахад хувь хүний санхүүгийн ухаалаг төлөвлөлт томоохон байр суурь эзэлнэ. Хувь хүн та өөрийн бүхий л талын нөөц бололцоог дайчлах, нийгэм, эдийн засаг, санхүүгийн үйлчилгээний талаарх өөрт хэрэгтэй мэдээллийг олж авах, олж авсан үнэн зөв мэдээллээ шийдвэр гаргах, сонголт хийхдээ оновчтой хэрэглэх, зөв мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлэхэд энэ сурах бичиг Танд тус болох нь дамжиггүй.

МОНГОЛБАНК  
ОЛОН НИЙТИЙН БОЛОВСРОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТӨВ



## 1.1. Өрхийн төсөв, түүний бүтэц

Монгол улс чөлөөт эдийн засгийн харилцаанд шилжсэнээр нийгэм эдийн засгийн болон өрх гэрийн амьдралд ихээхэн өөрчлөлт гарсан. Өрх гэр бүл бол хүний хөгжил, төлөвшлийн анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж, соёл, зан заншил, уламжлал өвлөгдөн шинэчлэгдэх, аж төрөх ёсны бичил ахуй мөн.

**Өрх гэр:** Нэг орон байранд амьдардаг, нэгдмэл төсөвтэй, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтдаа хангадаг хүмүүсийн нэгдэл юм.

Өрхийн орлого, зардлыг тооцож, төсөвлөх нь өрхийн гишүүдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, хүртээмжтэй хуваарилалт хийх, хуримтлалыг бий болгоход ихээхэн ач холбогдолтой юм. Төсвийг өрхийн гишүүдийн хэрэгцээнд хуваарилах мөнгөний тооцоолол, төлөвлөгөө гэж ойлгоно.

**Өрхийн төсөв:** Мөнгөн хөрөнгийг бүртгэж, захиран зарцуулах тоон төлөвлөгөө юм. Хамгийн энгийн байдлаар тодорхойлбол, өрхийн мөнгөн орлого, зарлагын төлөвлөгөөг өрхийн төсөв гэнэ.

Өрхийн төсвийн зорилго нь өрхийн гишүүдийн материаллаг болон оюун санааны хэрэгцээг өрхийн хязгаарлагдмал нөөцөөр бүрэн дүүрэн хангахад чиглэдэг. Иймээс өрхийн төсвийн гол үүрэг нь өрхийн орлогыг зөв, үр ашигтай хуваарилж, зарцуулахад оршдог. Мөнгөө зөв зүйлд зарцуулж, хуримтлал үүсгэхийн тулд төсөв зохиож, төсвийн дагуу зарцуулах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, мөнгө санхүүгээ зөв удирдаж, амьдралаа ухаалгаар авч явахад тань өрхийн төсөв тусална.

### ТАНЫ МЭДЛЭГИЙН САНД

Монгол улс 1935 онд 198792 өрхтэй байсан бол 2015 онд 859106 болж өдгөө 80 жилийн хугацаанд 4,3 дахин нэмэгджээ. Үүнээс улсын нийт хүн ам 3100000 гэж үзвэл нэг өрхөд 3-4 хүн ногдож байна. Өрхийн тоо, түүний бүтэц, ам бүлийн тоо нь хүн ам зүйн үндсэн үзүүлэлтийн нэг мөн.




Төсөв нь орлого, зарлага гэсэн үндсэн бүтэцтэй байх бөгөөд өрхийн төсвөөс тухайн өрхийн гишүүдийн олж буй орлого (жишээлбэл, цалин хөлс), мөнгөний зарцуулалт, хуримтлал, хадгаламж, өр төлбөрийн хэмжээг харж болно.

Зураг 1.1. Өрхийн төсвийн үндсэн ойлголтууд




Гэр бүлийн гишүүдийн нас, хүйс, боловсрол, эрхэлж буй ажил, мэргэжил зэргээс хамаараад өрхийн орлого харилцан адилгүй эх үүсвэрээс бүрддэг. Зарим өрхийн орлого зөвхөн цалин, хөдөлмөрийн хөлсний орлогоос бүрддэг бол заримынх нь бизнесийн, түрээсийн гэх мэт олон төрлийн орлогын эх үүсвэртэй байна.

Зураг 1.2. Өрхийн орлогын ангилал



Өрхийн орлогыг олон шинжээр ангилж болох бөгөөд Зураг 1.2-т үзүүлсэн ангилал нь ХХОАТ-ын зорилгоор хийсэн ангилал юм. Үүнээс гадна жил бүр МУ-ын ҮСХ-ноос өрхийн сарын дундаж орлогын бүтцийг тодорхойлон гаргадаг. Үүнийг Зураг 1.3-аас харна уу.

Зураг 1.3. Монгол Улсын нэг өрхийн сарын дундаж орлогын бүтэц /2017 он/




Эх сурвалж: МУ-ын ҮСХ.




## ТАНД СОНИРХУУЛАХАД

Өрхийн сарын дундаж мөнгөн орлого, 2018 оны 1- улиралд, төгрөг



Өрхийн сарын дундаж мөнгөн зарлага, 2018 оны 1- улиралд, төгрөг





Зураг 1.4. Өрхийн орлого нэмэгдүүлэх боломж

Өрхийн орлогыг гэр бүлийн гишүүдийн хэрэгцээг хангахад зарцуулдаг. Өрхийн орлого хязгаарлагдмал, хэрэгцээ хязгааргүй байдаг тул гишүүдийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангахын тулд өрхийн орлогыг нэмэгдүүлэх шаардлагатай болдог. Үүний тулд өрхийн боломж, гишүүдийн тоо, бүтэц, нас, хүйсийн онцлогоос хамаарч орлого нэмэгдүүлэх боломжийг ашиглах хэрэгтэй. Өрхийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг Зураг 1.4-өөс харна уу.



Манай улсын нийт өрхийн сарын орлогыг ангилж үзэхэд тал хувь нь сарын 1,030,919 төгрөгөөс бага орлоготой байгаа бол 13 хувь нь тэднээс 2-3 дахин их орлоготой байна. Олохоосоо илүү ухаалаг зарцуулах нь санхүүгийн бэрхшээлээс гарах гарц байх болно. Иймээс өрхийн төсөв зохиоход зардлын төсөв чухал ач холбогдолтой. Зардлаа төлөвлөхдөө мөнгөө хэрэгцээт зүйлд зарцуулах, мөнгө хэмнэх боломжуудыг ашиглахад анхаарах хэрэгтэй.





## 1.2. Өрхийн төсөв зохиох аргачлал

Өрхийн төсөв зохиохдоо хамгийн багадаа 3 сарын турш орлого, зарлагаа нэг бүрчлэн бүртгэсэн байх ёстой. Бидний хамгийн гол асуудал бол орлого, зарлагаа бүртгэж хөтөлдөг байх явдал юм. Өрхийнхөө орлого, зарлагыг бүртгэснээр та ашиг, алдагдал болон цэвэр хөрөнгийнхөө дүнг тооцож чадна. Энд өрхийн гишүүд ямар нэгэн хэмжээнд бүгд оролцоотой байх ёстой. Төсвөө хэлэлцээд шийдвэрлэсэн бол аль болох чанд баримтлах нь зүйтэй.

Санхүүгийн сахилга сайтай өрхүүд улирал, хагас болон бүтэн жилээр өрхийн төсвийн төлөвлөгөөгөө гарган мөрддөг. Үүний тулд ихээхэн хэмжээний орлого, зарлагаа урьдчилж тооцоолсон байна. Өрхийнхөө төсвийг тогтмол хөтлөх явцдаа тодорхой хугацаанд хянаж, шинжилгээ хийгээд өнгөрсөн хугацаанд ямар зүйлд мөнгө их зарцуулсан, юунаас хэмнэлт гаргаж чадсанаа дүгнэж байх шаардлагатай. Энэ үйл явцад хамгийн чухал нь өрхийн гишүүн бүр тооцоотой байх хандлагын болоод үйлийн өөрчлөлт бий болгож байвал үр дүн харагдана.

Зураг 1.5. Өрхийн төсөв зохиох үе шат

Зорилгоо тодорхойлох

Зорилгодоо хүрэх арга зам, хувилбаруудыг тодорхойлох

Зорилгоо хэрэгжүүлэх арга замаа сонгох

Төсөв зохиох

Төсвөө хэрэгжүүлэх

Төсвөө хянах, сайжруулах

Өрхийн төсөв зохиох хэд хэдэн арга байдаг бөгөөд Зураг 1.6-д өргөн ашигладаг, нийтлэг аргуудыг харууллаа.



Зураг 1.6. Өрхийн төсөв зохиох аргачлал



## ДУГТУЙТ ТӨСВИЙН АРГА

Зардлын төрөл бүрээр дугтуй бэлтгэн өрхийн төсвийнхөө тооцоог хуваарилж, төлөвлөгөөтэй зарцуулах арга юм. Америк болон Солонгос, Хятад улсад өргөн хэрэглэдэг. Энэ арга олон айл өрхөд үр ашгаа өгч чадсан байдаг. Дугтуйт төсвийн аргыг хэрэгжүүлэхийн өмнө орлого, зарлагаа бүртгэх бөгөөд түүнд үндэслэн орлого, зарлагаа төлөвлөнө. Өрхийн орлогыг зарцуулахын өмнө бага ч болов мөнгийг хуримтлалдаа тогтмол хийсний дараа хэрэглээнд хуваарилна. Орлого хэрэглээнээс илүү гарвал хадгаламжаа нэмэгдүүлэх нь зүйтэй.

Энэ аргын гол агуулга бол өдөр болон сараар нийтлэг гардаг зардлуудаа тус тусад нь дугтуйнд хийнэ. Жишээ нь: Хоол хүнс 200000 төгрөг, унаа тээвэр 75000 төгрөг, өр зээл 280000 төгрөг, хадгаламж 200000 төгрөг гэх мэт.




## КОМПЬЮТЕРИЙН СИСТЕМИЙН АРГА

Компьютер, гар утас дээр ажиллах дуртай хүмүүст олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн “Төсөвчин” хэмээх ашиглахад хялбар цахим хувилбарыг санал болгож байна. Өрхийн төсвийг цахим хэлбэрээр интернетэд холбогдсон үед компьютер, ухаалаг гар утсан дээр нэмэлт програм суулгахгүйгээр ашиглах боломжтой. Энэхүү програм нь төсвөө өөрийн хэрэгцээ шаардлагад тохируулан хөтлөх боломж олгодог бөгөөд хэрэглэхэд маш хялбар юм. Уг үнэгүй аппликейшны “IOS” ба “Android” хувилбарууд байдаг.

Өрхийн төсөв зохиохдоо тодорхой түвшинд алхамчлах хэрэгтэй. Жишээ нь: Өрхийнхөө орлого, зарлагыг бүртгэх, зарлагынхаа түүхийг дүгнэж, тэвчиж болох зардлаа олж илрүүлэн, өрхийнхөө төсвийг зохиох, өрхийн төсвөө чанд мөрдөн санхүүгийн сахилгатай байх.

- Өрхийн төсвийн үндсэн зарчим
- Өрхийнхөө төсвийг нэг байлгаж, шийдвэрийг хамтдаа хэлэлцэж гаргах;
- Хадгаламжийнхаа дансыг хоёр хүний нэртэй, мөн хоёр хүний гарын үсэгтэй байлгаж;





## ХҮСНЭГТИЙН АРГА<sup>1</sup>

Өрхийн төсвийг янз бүрийн хэлбэрээр хөтлөх боломжтой. Энэхүү хүснэгтийн аргачлал нь сонгодог аргачлал ашигласан цаасан дээр бүртгэх хувилбар юм.

Төсвөө ямар хугацаанд хөтлөхөө төлөвлөж, өөртөө зорилго тавиарай. Хоёр сарын дараа гэхэд та орлого зарлагаа харьцуулах боломжтой болно. Гурав буюу түүнээс дээш сарын дараа зарлага өндөртэй сар болон орлого, зарлага их хэлбэлздэг мөчлөгийг тодорхойлж чадна.

### Өрхийн төсөв зохиох

#### 1-р алхам: Орлогоо тооцох

##### + Орлого

Юун түрүүнд өрхийн орлогын жагсаалтыг өгөгдсөн загварын дагуу гаргаж үзээрэй. Сар бүрийн орлогоо эх үүсвэрээр нь ялгаж бүртгээрэй. Жилийн эцсийн нийлбэр дүнг мөрийн дагуу нэмж гаргана.

#### 2-р алхам: Тогтмол зарлагаа тодорхойлох

##### -Тогтмол зарлага

Энэ нь сар, улирал, хагас жил тутамд төлвөл зохих дүн юм. Жишээ нь: Цахилгаан, байрны төлбөр, утасны төлбөр, авто машины татвар гэх мэт. Эдгээр зарлагыг олон сарын дундаж дүнгээр баримжаалан тооцно.

<sup>1</sup> Өрхийн төсвийн дэвтэр, өрхийн санхүүгий удирдах зөвлөмж



### **3-р алхам: Тогтмол бус зарлагаа тооцох**

#### **-Тогтмол бус зарлага**

Улирал, цаг агаар, өрхийн гишүүдийн тоо, баяр ёслол зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан зарцуулагдах ба хугацаа, мөнгөн дүнгийн хэмжээ нь байнга өөрчлөгдөж байдаг зарлагууд энд хамаарна. Жишээ нь: Өрхийн гишүүдийн хэрэглээний зарлага, тухайлбал хоол хүнс, ахуйн хэрэглээ, хувцас, үзвэр үйлчилгээ, хандив, бэлэг, аялал зугаалга гэх мэт.

### **4-р алхам: Төсөв зохиох**

#### **= Төсөв**

Орлого - тогтмол зарлага = Төсөв

Зарцуулах мөнгөний төсвөө сар сараар нь харах боломжтой болгох, үүний үр дүнд төсөв бага байгаа үеийг хэрхэн даван туулахаа төлөвлөх юм. Цаашид төлбөрийн ачааллаа тэнцвэржүүлэхийн тулд их хэмжээтэй, тогтмол дүнтэй зарлагад зориулан хуримтлуулах, зарим төлбөрийг хуваан төлөх гэх мэтээр зохицуулалт хийж болно.

### **5-р алхам: Гарт үлдэх мөнгөө тооцох**

#### **= Гарт үлдэх мөнгө**

4-р алхамд тооцсон төсвөөс тогтмол бус зарлагаа хасвал гарт үлдэх мөнгөн дүн гарна. Ирээдүйн худалдан авалтандаа зориулан хуримтлуулах, санхүүгийн гэнэтийн хямралд өртөхгүйн тулд гарт үлдэх мөнгийг аль болох нэмэгдүүлэхийг зорих хэрэгтэй.



Загвар

Орлого	1-р сар	2-р сар	3-р сар	Нийт дүн
Баярагын илалт (татварын дараах)	736 000	736 000		8 832 000
Огноогийн илалт (татварын дараах)	641 000	641 000		7 692 000
Хадгаламжийн хүүний орлого	15 000			60 000
Хүүхдийн мөнгө	40 000	40 000		480 000
Уралтшударал		200 000		600 000
<b>Нийт орлого</b>	<b>1 432 000</b>	<b>1 617 000</b>		<b>17 664 000</b>
<b>Тогтмол зарлага</b>	<b>1-р сар</b>	<b>2-р сар</b>	<b>3-р сар</b>	<b>Нийт дүн</b>
Баярны зээлийн төлбөр /түрээс/	420 000	420 000		5 040 000
Уухийн	18 000	18 000		216 000
Уур	8 000	8 000		96 000
Тар утас / 2 утас/	24 000	24 000		288 000
Кабелийн тв, интернет, гэрийн утас	39 000	39 000		468 000
Сонин захиалга	14500			58 000
Сонгон дурдлагын төлбөр	30 000	30 000		360 000
Эрүүл мэндийн даатгал	6 000	6 000		72 000
Жалогчийн харуулалтын даатгал	34 000			34 000
Авто машины татвар		76 000		76 000
Орон сууцны даатгал	30 000	30 000		360 000
Тэнгэрийн оллын даатгал	4 500	4 500		54 000
Хадгаламж	165 000	165 000		1 980 000
Зээл /авто машины зээл/	310 000	310 000		3 720 000
Нийтийн тээвэр /автотусуу/	24 000	24 000		288 000
<b>Нийт тогтмол зарлага</b>	<b>1 127 000</b>	<b>1 154 500</b>		<b>13 168 000</b>
<b>Төсөв</b>	<b>305 000</b>	<b>462 500</b>		<b>4 496 000</b>
<b>Тогтмол бус зарлага</b>	<b>317 000</b>	<b>371 500</b>		<b>4 432 000</b>
<b>Гарт үлдэх мөнгө</b>	<b>-12 000</b>	<b>91 000</b>		<b>64 000</b>



### Жилийн төсөв

+ Орлого	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар
Нийт орлого						

- Тогтмол зарлага	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар
Нийт тогтмол зарлага						

= Төсөв						
---------	--	--	--	--	--	--

- Тогтмол бус зарлага						
-----------------------	--	--	--	--	--	--

= Гарт үлдэх мөнгө						
--------------------	--	--	--	--	--	--



## САРЫН ЗАРЛАГЫН БҮРТГЭЛ

### Тогтмол бус зарлагаа бүртгэх

#### 1-р алхам – Зарлагаа ангилах

Тогтмол бус зарлага хэрхэн ангилах талаар 11 дүгээр хуудасны загвараас, мөн дэвтрийн төгсгөл хэсэгт өгөгдсөн жишээнээс харж болно. Мөн өрхийнхөө онцлогт тохируулан ангилж болно. 12 дугаар хуудаснаас эхлэн тогтмол бус зарлагаа ангилан бичээрэй.

#### 2-р алхам – Баримтаа цуглуулах

Худалдан авалт хийгээд ихэнх тохиолдолд кассын баримт эсвэл нэхэмжлэл авдаг. Баримтаа дугтуй эсвэл хайрцагт хадгалаарай. Бараагаа солих, буцаах эсвэл баталгаат хугацааны засварын үйлчилгээг ашиглахад худалдан авалтын баримт шаарддагийг санаарай. Баримт авч чадаагүй тохиолдолд тэмдэглэл хийх нь зохимжтой.

#### 3-р алхам – Зарлагаа бүртгэх

Өрхийн төсвийн дэвтэр, баримттай дугтуйгаа нүдэнд тусахуйц газар хадгалаарай. Ингэснээр зарлага гарсан даруйд бүртгэх юм. Өдөр бүр бүртгэх нь хамгийн тохиромжтой ба боломжгүй үедээ хамгийн багадаа долоо хоногт нэг удаа бүртгэвэл зохино.

#### 4-р алхам – Сарын зарлагыг тооцоолох

Зарлагаа ангилал бүрээр нь, мөн өдрийн зарцуулалтаар нь нэмж тооцоорой. Хүсвэл сарын дундуур нийлбэр дүнг гаргаж болно. Энэ дүнгээ дараах хуудас руу шилжүүлээд, бүртгэлийг үргэлжлүүлэн хөтөлнө.

Та өдрийн зарлага буюу ангилал бүрийн нийлбэр дүнг гаргаснаар сарын тогтмол бус зарлагын нийт дүнг тодорхойлж болно. Энэ дүнгээ жилийн төсөвт буюу 8, 9 дүгээр хуудсанд бөглөнө.





### 1-р сарын тогтмол бус зарлага

### Загвар

Өдөр	Хүнс, гадуур хооллох		Ахуйн болон хувц		Өдрийн нийт зарлага
	Зарлага	Дүн	Зарлага	Дүн	
1	Хүчинэй зах / мах, ногоо, гуриал, будаа/	60 000	Чочон	5 000	64 000
2	Сувдагмаркет / хайл, талх, тасло зах тэт/	10 000	Ариун дэврийн зэрлэ	15 000	25 000
3					
4	Сүү, тараг	3000			11 000
5			Баяраад аймо	2 500	32 500
6	Талх, боордго	3500			3500
7					
8					
9	Хүчинэй зах / сүү, тараг, талх зах тэт/	10 000	Тутал заовар	5 000	22 000
10	Өдрийн хоол / ажилтдын дааны газарт/	5000			19 000
11	Сүү, аарц	4500			17 500
12	Талх	2000			
13	Хүчинэй зах / ногоо, гуриал/	26 500	Эт	4 000	34 500
14					
15	Хүчинэй зах / тах/	40 000			49 500
16					
17	Зах / Сандраана/	10 000			22 500
18	Талх	2000			11 000
19					
20					
21					
22					
23					
24					
<b>Нийт</b>		<b>176 500</b>		<b>31 500</b>	<b>317 000</b>





## Орлого зарлагын жишээ

Орлого	Тогтмол зарлага		Тогтмол бус зарлага	
	Байр, орон сууц			
Цалин, хөлс ба түүнтэй адилтгах орлого	Үл хөдлөх хөрөнгийн түрээс, зээлийн эргэн төлөлт		Засвар, засал чимэглэл хийх	
Татварын дараах цалин, хөлс	Дулаан, түлш		Тавилга, эд хогшил авах	
Амралтын мөнгө	Цахилгаан		Дулаалга	
Урамшуулал	СӨХ			
Хувийн аж ахуйгаас олсон орлого				
Улсаас олгох	<b>Гэр ахуй</b>			
Хүүхдийн мөнгө			Цахилгаан хэрэгсэл	
Байр, орон сууцны тэтгэлэг			Ахуйн хэрэглээ	
Хүүхэд асрах үеийн тэтгэмж			Цэцэрлэгжүүлэлтийн хэрэгсэл	
Тэтгэвэр			Мал, амьтан/мал, амьтны татвар, арчилгаа бусад/	
Ажилгүйдлийн тэтгэмж			Гэр ахуйн засвар	
Бусад эх үүсвэрээс	<b>Хоол, хүнс</b>			
Тэтгэмж			Хүнс	
Мөнгөн бэлэг			Гадур хооллох	
Сугалааны хонжвор			Сургууль, цэцэрлэгийн хоолны мөнгө	
Өв залгамжлал				
Хөрөнгийн үр өгөөж	<b>Эрүүл мэнд ба биеийн арчилгаа</b>			
Хүү, ногдол ашиг	Эрүүл мэндийн даатгал		Гоо сайхны бараа	
Хадгаламжийн хүү	Эрүүл мэндийн клубын төлбөр		Үсчин, гоо сайхан	
Хувыцааны есөлтийн бодит ашиг	Гоо сайхны бараа		Эм, витамин, бэлдмэл	
Түрээсийн орлого	Ариун цэвэр, цэвэрлэгээний зүйлс		Эмчийн үзлэг, шинжилгээ, эмчилгээ	
Буцаан олголт				
Татварын хөнгөлөлт				
Эрүүл мэндийн даатгалын нөхөн төлбөр	<b>Хувийн хэрэглээ</b>			
			Хувцас	
			Үнэт эдлэл, цүнх, шүхэр	
			Угаалга, хими цэвэрлэгээ	
	<b>Унаа</b>			
	Нийтийн тээвэр		Хувийн тээврийн хэрэгсэл /шатахуун, салбар	
	Автомашинны зээлийн төлбөр		Такси, машин хөдөлгөө	
	Автомашинны татвар		Засвар, үйлчилгээ	
	Жолоочийн хариуцлагын даатгал		Зогсоолын төлбөр	
	<b>Автомашинны эд хөрөнгийн даатгал</b>			
	<b>Холбоо</b>		<b>Харилцаа</b>	
	Олон нийтийн радио, телевизийн хураамж		Бичиг хэргийн зүйлс, шуудан холбоо	
	Утас, интернет			
	Автомашинны татвар			
	<b>Боловсрол ба чөлөөт цаг</b>			
	Сургалтын төлбөр		Ном, сонин, сэтгүүл, тоглоом, спорт	
	Дугуйлан, секцийн төлбөр		Үзвэрийн тасалбар	
	Гишүүнчлэлийн төлбөр		Аялал, зугаалга, зочид буудал, амралтын газар, байр түрээслэх	
	Хүүхдүүдэд халаасны мөнгө		Бэлэг дурсгалын зүйлс	
			Хобби	
	<b>Асрамж ба халамж</b>			
	Цэцэрлэг /яслийн төлбөр		Бэлэг	
			Хандив	
	<b>Төлбөр, мөнгөн шагнал, мөнгөн гуйвуулга</b>			
	Хүүхдийн тэтгэмж, мөнгөн бэлэг		Хураамж	
	Бэлэг тусламж		Мөнгөн хандив	
	<b>Хуримтлал</b>			
	Хадгаламж			
	Тэтгэврийн даатгал			



“Өрхийн төсвийн дэвтэр”<sup>2</sup> товхимолыг ХБНГУ-ын Хадгаламжийн Банкны Олон Улсын Хамтын Ажиллагааны Сангаас Монголбанктай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд Монголын Банкны Холбоо, Хадгаламжийн Даатгалын Корпорацийн дэмжлэгтэйгээр боловсруулсан.

## ӨРХИЙН ТӨСВИЙН ДЭВТЭР

Өрхийн санхүүгээ удирдах зөвлөмж



<sup>2</sup> Энэхүү дэвтрийг үнэгүй тарагдхаар хэвлэсэн.



### 1.3. Өрхийн төсөв хөтлөлтийн давуу тал, ач холбогдол

Өрхийн төсөв хөтлөлтийн байдал Монгол Улсад хангалтгүй байна. 2010-2013 оны хооронд хийсэн түүвэр судалгаанаас харвал, өрхийн төсөв хөтлөлтийн байдал:

- Өрхийн төсөв огт хөтөлдөггүй 70 хувь;
- Өрхийнхөө төсвийг хааяа бүртгэдэг 25 хувь;
- Өрхийнхөө төсвийг бүрэн хөтөлдөг 5 хувь байна.

#### Өрхийн төсөв хөтлөх нь дараах давуу талтай. Үүнд:

- Гэр бүлд санхүүгийн маргаан гарахгүй, эхнэр, нөхөрт итгэлцэл бий болно.
- Гэр бүл бүх гишүүдийн хэрэгцээг хангах төлөвлөгөөтэй болно. Өрхийн төсвийн орлого, зарлага тэнцэх, үгүйг шийдвэрлэхэд хэрэгцээтэй материал нь болж байдаг. Өрхийн төсвийн бүртгэлийн дэвтэрт орлогын агуулга ба түүний шинж чанарыг сайн бүртгэснээр өрхийн төсвийн орлого, зарлага тэнцэх эсэхийг шийдвэрлэж байдаг.
- Нийгэм эдийн засгийн эрсдэлийг даван туулах арга замаа хайхад тусална.
- Өрх өөрийн төсвийн онцлог чанар, дадал зуршил, хэрэглээний өөрчлөлтийг харж болно.
- Санхүүгийн зорилготой болж төлөвлөсөн тооцоотой амьдралыг зохиоход хялбар болдог.

#### Өрхийн төсвөө хөтлөхгүй байх нь дараах сөрөг талтай. Үүнд:

- Гэр бүлийнхээ санхүүгийн онцлог чанарыг мэдэхгүй, хэт үрэлгэн зардал их гаргадаг.
- Гэнэтийн эрсдэл төлөвлөгөөгүй зардал гарах үед гэр бүлийн амьдрал хүндрэлд орно.
- Гэр бүлд санхүүгийн маргаан их гарна.



- Гэр бүл дэх гишүүдийн хэрэгцээ нь хангагдахгүйн улмаас зөрчил бий болно.
- Өдөр тутмын тооцоогүй амьдрал нь ирээдүйн эдийн засгийн эмзэг, ядуу байдалд хүргэх нь элбэг.
- Өрхийн төсөв хөтлөхгүй байх нь хадгалах, хуримтлуулах сэтгэлгээг бий болгохгүй байх хандлагатай юм.

Мөнгө их олдог хүн бүр баян байдаггүй. Харин хэрхэн яаж зарцуулахаас л хамаарна. Өнөөдөр та хэр зэрэг хөрөнгөтэй хүн бэ? Та дараах загварын дагуу өөрийн хөрөнгө болон өр төлбөрөө тодорхойлно уу.

### Хүснэгт 1.1. Хөрөнгө ба өр төлбөр

Хөрөнгө (А)		Өр төлбөр(Б)	
1	Бэлэн мөнгө		Хувь хүнд төлөх өр
2	Хадгаламж		Банкны зээл
3	Авлага		Ус, цахилгааны төлбөр
4	Хашаа байшин		
5	Газар		
6	Автомашин		Бусад өр төлбөр
7	Мал		Өр төлбөрийн дүн
	Хөрөнгийн нийт дүн		Цэвэр хөрөнгө(В)

Цэвэр хөрөнгийн хэмжээг олохдоо хөрөнгийн нийт дүнгээс өр төлбөрийн нийт дүнг хасна. Өөрөөр хэлбэл,  $B=A-B$  гэсэн томъёог ашиглана.

Та өрхийн төсвөө цахим байдлаар хөтлөх бол [www.sankhuugiinbolovsrol.mn](http://www.sankhuugiinbolovsrol.mn) хаягаар орж нэмэлт мэдээлэл авч ашиглах боломжтой. Мөн “Төсөвчин” аппликейшнийг үнэгүй IOS, Android утсандаа суулган ашиглаарай.




“Хүн нэг өглөө босоод л  
санхүүгийн мэдлэгтэй болдоггүй”

Шон мэнди  
(Дэлхийн банкны зөвлөх)











## ТӨСӨВЧИН Аппликэйшн



Энэхүү аппликэйшн нь өөртөө хуримтлал тооцоологч,  
хадгалагч, зээл тооцоологч, ипотек, төсөвлөгч зэрэг  
тооцоолууруудыг багтаасан.

[www.sankhuuginbolovsrol.mn](http://www.sankhuuginbolovsrol.mn)



-  /Mongolbank.mn
-  /Санхүүгийн боловсрол
-  @mongolbank\_mn
-  [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)
-  /Mongolbankmn
-  [info@mongolbank.mn](mailto:info@mongolbank.mn)
-  11 310081